



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/351

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2023 оны 18 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.4.10 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “50 өрхийн вакумжуулсан сургалт” зохион байгуулах, “Явуулын сэтгэл зүйн үйлчилгээ”-г тус тус үзүүлэхэд зориулж 30,000,000 (гучин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх зардлаас олгохыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Х.Уртнасан)-д, хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 06 дугаар сарын 20-ны
... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Нийт үнэ ₮
1	Сэтгэл зүйн үйлчилгээний хөлс	17.000.000
2	Сургалт, үйлчилгээний зардал	13.000.000
	Нийт зардал	30.000.000